



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 313

Улаанбаатар хот

### Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” ХХК-ийн нэг бүр нь 20 /хорь/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 200,000,000 /хоёр зуун сая/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Түмэн шувуут” ХХК-ийн нэг бүр нь 20 /хорь/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 150,000,000 /нэг зуун тавин сая/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 50,000,000 /тавин сая/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 200 /хоёр зуу/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Түмэн шувуут” ХХК /Ж.Болд/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Түмэн шувуут” ХХК /Ж.Болд/-д мэдэгдсүгэй.

5. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 4-т заасан нийтэд санал болгон худалдах хувьцааны 100 /нэг зуу/ хувь анхдагч зах зээлд арилжаалж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /О.Мөнхжаргал/-д анхааруулсугай.

8. “Түмэн шувуут” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Түмэн шувуут” ХХК /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Голомт капитал ҮЦК” ХХК /О.Мөнхжаргал/, “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН /Ж.Майзориг/, “Итгэлт Эстимэйт” ХХК /Ө.Эрдэнэбаяр/, “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК /Б.Осоргарав/-д тус тус анхааруулсугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны 12 дугаар сарын 14-ний  
өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны эзэмшлийн хувь
1	Ломбын Эрхэмбаяр	60,000,000	30%
2	Балайгийн Тунгалаг	60,000,000	30%
3	Жигжидийн Болд	15,000,000	7.5%
4	Эрхэмбаярын Баяржаргал	15,000,000	7.5%
	Нийт дүн	150,000,000	75%